

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10 дахь хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.5, 65.6 дахь хэсэг, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дэх заалт, 7.4, 7.7, 7.10, 7.11 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.11.6 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 09 цаг 00 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байрны 1 дүгээр давхарт хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
 - 2.2. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Зохион байгуулах комиссыг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Рандолф Коппаг томилсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын Хавсралт 3-ийн дагуу баталж, уг зарыг Монголын хөрөнгийн бирж, Худалдаа, хөгжлийн банкны цахим хуудсаар болон олон

нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2024 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т үүрэг болгосугай.

7. Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг энэхүү тогтоолын Хавсралт 4-ийн дагуу баталж, танилцах боломж нөхцөлөөр хангахыг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, шийдвэрийн төсөл, саналын хуудас болон тэдгээртэй холбоотой баримт бичгийг 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн дотор Үнэт цаасны компаниудад хэвлэмэл эсхүл цахим байдлаар хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т үүрэг болгосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдрөөр тогтоосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Монголбанканд хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг энэхүү тогтоолын Хавсралт 5-ын дагуу баталсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг энэхүү тогтоолын Хавсралт 2-т заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд урьдчилан санал хүргүүлж буй Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2024 оны 4 дугаар сарын 17-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл цахим хэлбэрээр болон Худалдаа, хөгжлийн банкны төв байран дээр хүлээн авах, Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын хүлээсэн үүргүүдийг хэрэгжүүлэхийг Тооллогын комисс (Л.Одмаа)-т үүрэг болгосугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



РАНДОЛФ КОПША

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар
сарын 18-ны өдрийн 22. тоот тогтоолын
Хавсралт I



**Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурал зохион байгуулах комисс**

Комиссын дарга:

Н.Нямсүрэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга;

Комиссын гишүүд:

Ц.Ганбаяр

Хууль, эрх зүй хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч;

Д.Энхтуяа

Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал;

Т.Батжаргал

Хуулийн газрын захирал;

Ш.Сэлэнгэ

Маркетингийн газрын захирал;

Г.Энхлхагва

Стратеги, хөгжил, инновацын газрын захирал;

Х.Ууганбаяр

Технологи, инновацын хэлтсийн захирал;

Л.Сайнбаяр

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны гадаад харилцааны мэргэжилтэн;

Х.Оюутсэцэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны хуульч.

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3-дугаар
сарын 18-ны өдрийн 21 тоот тогтоолын
Хавсралт 2



**Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тооллогын комисс**

Тооллогын комиссын дарга:

Л.Одмаа

Дотоод аудитын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч;

Тооллогын комиссын гишүүд:

Л.Анхбаяр

Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал;

А.Болормаа

Комплайнсын хэлтсийн захирал;

Б.Энхжаргал

Тусгай аудитын хэлтсийн ахлах аудитор;

Н.Тэмүүлэн

Эрх зүйн бодлогын хэлтсийн хуульч;

А.Энхжаргал

Ерөнхий аудитын хэлтсийн аудитор;

Б.Саруулбуян

Ерөнхий аудитын хэлтсийн аудитор.

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцах журам:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид дараах арга, хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай 2024 оны 4 дүгээр сарын 17-ний өдрөөс эхлэн танилцаж болно. Үүнд:

- ХХБ-ны investor.tdbm.mn цахим хаягт хандан танилцах;
- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандан танилцах;
- Худалдаа, хөгжлийн банкны төв байранд ажлын өдрүүдийн 10:00-17:00 цагийн хооронд Хурал зохион байгуулах комисст хандан танилцах.

8. Хуралд оролцох, санал өгөх заавар:

Хувьцаа эзэмшигч Та дараах аргуудын аль нэгээр хуралд оролцож санал өгөх боломжтой. Үүнд:

Танхимаар оролцох:

- Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигчид хурлын өдөр буюу 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 8 цаг 30 минутаас эхлэн 8 цаг 50 минут хүртэл бүртгэлээ хийлгэж, танхимд нэвтэрсэн байна.
- Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигч нь:
 - Хувь хүн бол: Хүчин төгөлдөр иргэний үнэмлэх эсхүл гадаад паспортыг шалгуулан танхимд нэвтэрнэ. Итгэмжлэгдсэн төлөөлөгч бол нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэлийн хамт хүчин төгөлдөр иргэний үнэмлэх эсхүл гадаад паспортыг шалгуулан нэвтэрнэ.
 - Хуулийн этгээд бол: Хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцож буй этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хувьцаа эзэмшигчийн хуралд төлөөлөн оролцох эрх бүхий этгээдийг томилсон шийдвэр (Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол гэх мэт)-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Тооллогын комисст хүлээлгэн өгч, өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэх эсхүл гадаад паспортыг шалгуулан танхимд нэвтэрнэ.

Цахимаар оролцох:

- Хуралд зайнаас оролцох хувьцаа эзэмшигчид 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 8 цаг 50 минутаас өмнө investor.tdbm.mn цахим хуудаст хандан зааврын дагуу хуралд цахимаар оролцож, саналаа өгнө.

Урьдчилсан санал өгөх:

- Цаасан хэлбэрээр санал өгөх: Саналын хуудсыг 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл Худалдаа, хөгжлийн банкны төв байранд Тооллогын комисс хүлээн авна.
- Цахим хэлбэрээр санал өгөх: Худалдаа, хөгжлийн банкны investor.tdbm.mn цахим хуудсанд хандан 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл саналаа өгөх боломжтой.

9. Хурал зохион байгуулах болон Тооллогын комисстой холбоо барих мэдээлэл:

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 14210, Энхтайваны өргөн чөлөө
19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банкны төв байр

Утас: 11 328227

Цахим хаяг: boardoffice@tdbm.mn

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар
сарын 18-ны өдрийн 21 тоот тогтоолын
Хавсралт 5



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Компанийн оноосон нэр: “Худалдаа, хөгжлийн банк” ХК
Компанийн хаяг: Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байр
Хурал хуралдах газар, өдөр: 2024 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 9:00 цагт
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны төв байрны 1 дүгээр давхарт
(танхим болон зайнаас хосолсон хэлбэрээр хуралдана.)
Зайнаас: investor.tdbm.mn цахим хаягаар.

Санал өгөх ерөнхий заавар:

- Хувьцаа эзэмшигч нь хурлын бүртгэлийн өдөр буюу 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгнө.
- Тэмдэглэгээ хийгээгүй, засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд урьдчилан санал хүргүүлэх Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл Худалдаа, хөгжлийн банкны төв байранд эсхүл холбогдох зааврын дагуу investor.tdbm.mn цахим хуудсанд хандан Тооллогын комисст хүлээлгэн өгнө.
- Хувьцаа эзэмшигч хувь хүн нь өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулж, энэхүү саналын хуудаст хавсаргана.
- Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хувьцаа эзэмшигчийн хуралд төлөөлөн оролцох эрх бүхий этгээдийг томилсон шийдвэр (Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол гэх мэт)-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбарыг энэхүү саналын хуудаст хавсаргана.

Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр, нэр:	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар:	
Хувьцаа эзэмшигчийн цахим шуудангийн хаяг:	
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй хувьцааны төрөл:	Энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо:	

Санал хураах арга: Ердийн

Ердийн аргаар санал өгөх заавар: Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, өөрийн сонгож буй саналын нүдэнд (✓) эсхүл (+) тэмдэг тавина.

№	Хэлэлцэх асуудал	Хувьцаа эзэмшигчийн санал		
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай			
2	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг:

Зааварчилгаа:

Хувьцаа эзэмшигч та хувь хүн бол “Хувьцаа эзэмшигч хувь хүн бөглөнө.” хэсэгт, хуулийн этгээдийг төлөөлөн оролцож буй бол “Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бөглөнө.” хэсэгт гарын үсэг зурах шаардлагатайг анхаарна уу.

Хувьцаа эзэмшигч хувь хүн бөглөнө. Хувьцаа эзэмшигчийн Нэр: Гарын үсэг:	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бөглөнө. Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн Нэр: Албан тушаал: Гарын үсэг:
2024 оны ... -р сарын ...-ны өдөр	
Тооллогын комисс бөглөх хэсэг:	
Саналын хуудсыг хүлээлгэн авсан огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан Тооллогын комиссын гишүүний нэр, гарын үсэг:	

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм Үгүй

Комиссын дарга: / /

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

.....